

Монгол, өрнө, дорнын гэр бүл судлалын асуудалд

Доктор Т.Намжил

Оршил

Орчин үед дэлхийн улс орнууд урьд хэзээ ч байгаагүйгээр ойртон холбогдож, бие биенээс хамаарах явдал олон улсын хөгжлийн ерөнхий хандлага болж байна.

Аль ч улс орнууд уялдаа холбоотой, харилцан хамааралтай оршихын зэрэгцээ өөр өөрсдийн амьдран буй тив болон дэлхий дахины хэмжээнд хүч, бололцоогоо нэгтгэн тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхэд чармайлтаа дайчлах эрмэлзлэл сүүлийн жилүүдэд идэвхжлээ.

Улс орнуудын харилцан холбоог дагалдан бидний суудаг Ази тив нь бүс нутгийн, дэлхий дахины хамааралтай үйл явцад шилжиж, харилцаа жилээс жилд өргөжин хөгжсөөр байна.

Хоёр талын болон олон талын харилцааны явцад “бүс нутаг”, “тив” гэдэг томъёолол зөвхөн газар зүйн ойлголт байхаа больж, улс төр, нийгэм - эдийн засгийн үйл ажиллагааны агуулгыг илэрхийлэн дэлхийн улс төр - эдийн засгийн хэллэгт байр сууриа нэгэнт эзлэх боллоо.

Дэлхийн улсуудтай нягт холбоо тогтоон хамтын ажиллагааг өрнүүлэхийг Монгол улс зорихдоо урьд их, бага, хэмжээгээр тогтоосон уламжлалт харилцаа зэрэг хүчин зүйлсийг анхааран үзэж байна.

Судалгаа, шинжилгээний байгууллагын ажлын үндсэн чиглэлд ард түмнүүдийн түүх, соёлын уламжлал, зан заншил, ахуй амьдралын судалгаа нэг гол суурийг эзэлж байна. Энэ чиглэлээр шинжилгээний ажил нилээд өргөжиж, судлаачдын тоо ч нэмэгдэх болов.

Хятад, Солонгос Япон, Герман, Франц, Орос, Англи, Энэтхэг зэрэг олон орны Монгол судлаач эрдэмтдийн дунд ч түүх, соёлын харьцуулсан судалгаа хийгдэж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол судлал хэлний үзэгдлийг хооронд нь харьцуулан судлах хүрээнээс хальж, түүх, утга соёлын нийтлэг болон нийтлэг бус асуудлыг хамруулан хүн судлал, угсаатны судлал, эртний судлал, аман зохиолын хэрэглэгдэхүүнийг ашиглан утга учрыг нь шинжлэх ухааны тогтолцооны үүднээс судлах хандлагатай болж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн зарим орны тухайлбал Францын А.Я. Гуревич, Монголын Г.Сүхбаатар зэрэг эрдэмтэд түүхийн судалгаанд түүхэн процессын субъектив, сэтгэл судлалын талыг чухалчилсан санал дэвшүүлсэн. Түүх судлалын тун зүйтэй чиглэл юм. Учир юу вэ? гэвэл Нийгмийн түүх бол хүний харилцсан, үйлчлэлцсэн, нөлөөлөлцсөн үйл ажиллагааны систем, нийлбэрийн түүх, гэр бүлийн хүрээнд авч үзвэл эцэг

*. ШУА-ийн Олон улсын судлалын хүрээлэнгийн
тэргүүлэх ажилтан

эх, хүүхдүүдийн хоорондох харилцааны нийлбэр цогцос болсоор ирсэнтэй холбоотой.

Энэ нь улс орнуудын угсаатны гэр бүлийн хоорондын харилцааны агуулга болно. Тиймээс аль ч оронд гэр бүлийн түүхийн судалгаа нь нийгмийн түүхийн судалгааны нэг гол тал болох ёстой.

Гэр бүлийн түүх гэдэг бол нэгэн айл өрх тухайлбал, Их гэр бүлийн гишүүд (өвөө, эмээ, эх эцэг, хүүхдүүд, ач зээ) байгалийн ба нийгмийн бодит нөхцөл байдлын байнгын нөлөө, үйлчилгээний дор амьдарч, ажиллаж, харилцаар, бие биедээ тус дэм болсоор ирсний тухай мэдээлэл юм.

1860-аад он хүртэл өрх гэрийн түүхийн тухай ярих ч аргагүй байжээ. Учир нь Ф.Энгельсийн дүгнэн бичсэнээр өрх гэрийн түүхийн шинжлэх ухаан Монсейн “өрх гэрийн эцгийн эрхт үеийн хэлбэрийг хамгийн эртний хэлбэр”, “өрх гэр ер нь ямар ч түүхт хөгжлийг туулаагүй мэт”-ээр үзэж байсантай холбоотой. Өрх гэрийн түүх судлах явдал Баховены “Эхийн эрхт ёс” гэдэг ном хэвлэгдэн гарсан 1861 оноос эхэлжээ.

Монгол ёс, зан заншил монголчуудын өвөг - Хүннүгээс эхлэн эртний өвөг улсуудын түүх, шашдирт тэмдэглэгджээ. Монголын Нууц товчоо ч Монгол ёс, зан заншлыг мэдэх нэг гол сурвалж болдог.

Эртний Хятадын болон өрнө, дорнын эрдэмтэн мэргэдийн бүтээл, жуулчдын тэмдэглэл, номонд Монгол ёс, зан заншлын мэдээ тусгалаа олж байжээ. Монгол ёс, зан заншлын талаар Монголын эрдэмтэн мэргэдийн бичсэн нь арвин их.

БНМАУ-ын түүхийн болон Угсаатны зүйн ботиудад монгол ёс, зан заншлын уламжлалыг тусгасан байна.

Монголчуудтай удам гарал, хэл, түүх, соёл, аж ахуй зэргийн элдэв хэлхээ сүлбээ бүхий байсан харь удмын овог ястны талаар чухал зохиол гадаадад нилээд гарчээ.

Орчин үед гэр бүлийн судалгаа дэлхий дахины чиглэлтэй болж эхэлж байна. Тухайн улс орнуудын төдийгүй Төв, Баруун Европ (6), Орос (5), Америк (8), Солонгос (9), Япон (7) гэх зэргээр тив, бүс нутгийн хэмжээнд гэр бүлийн судлалын бүтээлүүдийг гаргах боллоо.

Вена дахь нийгмийн түүх, эдийн засгийн институтын ажилтан, гэр бүлийн түүх судлаач Райнхард Зидер Нийгмийн түүхийн салбарт “Гэр бүлийн түүхийн судалгаа”-г нэг гол чиглэл болгохын төлөө олон жил ажилласны дүнд Баруун, Төв Европын сүүлийн хоёр зуу гаруй жилийн гэр бүлийн нийгмийн түүхийн асуудлаар туурвисан бүтээлд гэр бүлийн хөгжлийн түүхэн гол (гэрийн хөдөлмөр, эцгийн эрхт ёс, нийгэм, гэр бүлийн тогтолцоон дахь хувьсал, гэр бүлийн эзлэх байр суурь, гэрлэлтийн зан үйл, үр хүүхдэд ахмадын харилцаа, бэлгийн харьцаа зэрэг) асуудлыг гаргасан (6).

Р.Зидерээс гэр бүлийн нийгмийн түүхийн талаар хийсэн судалгаа нь Евразийн гэр бүлийн түүхийн судлалд шинжлэх ухааны арга зүйн ач холбогдолтой бүтээл юм.

Гэр бүлийн судлал түүхэн угсаатны зүйн улмаар нийгмийн түүхийн шинжлэх ухааны (схем 1-ээс үзнэ үү) үүднээс хөгжих болж байгаа нь бидний анхаарлыг татаж байгаа юм.



Схем 1. Угсаатны зан заншлын харилцан нөлөөллийг судлах шинжлэх ухааны холбоо

Монголчуудын зан заншлыг өрнөд, дорнын орны ард түмнүүдийнхтэй харьцуулан судлаж шинжлэх асуудал Монголын эртний түүхийн маш сонин, эгзэгтэй асуудал. Энэ нь Монгол угсаатны гарваль ба Монгол нутгаас мандаж гарсан Төв Азийн нүүдэлчин аймаг туургатны түүхэн хөгжлийн нилээд асуудлыг шийдэж нэгэн тийш болгохтой шууд биш ч гэсэн шүтэн барилдаж байгаа юм.

Монголчуудын зан заншлын судлал бидний өвөг дээдэс дэлхийн аль газар орон, угсаатантай ямар ямар зүйлээр хэлхэлдэн сүлбэлдсэнийг зөв таамаглахад туслана гэж үзэж байна.

Ингэснээр: - Монголчуудын гэр бүлийн түүх судлал нь тохиолдлын бус, дэлхийн гэр бүл судлалтай холбоотой болно.

- Монголчуудын гэр бүлийн түүхийн уламжлалыг тусгайд нь онцгойлон авч үзэх үзлээс ангид байх бололцоог олно.

Академич Н.Ишжамцын онцлон тэмдэглэснээр:

“Монголчуудын зан заншлын асуудлыг авч үзэхдээ ямар ч үед түүнийг гадаад ертөнцөөс бөглүү тасархай, хэтэрхий өвөрмөц онцгой байснаар дүрслэн сэтгэж болохгүй, хэрэв тэгвэл онол, арга зүйн алдаа болно”.(1.125)

Монгол, Өрнө, Дорно дахины орнуудын гэр бүлийн зан заншлын уламжлал нь ард түмний туулж ирсэн мэдлэгийн тодорхой төвшин хийгээд түүхэн тодорхой үеийг тусгасан, үндэсний шинжийг агуулсан онцлогтой байдаг (2.212) байна.

Эртний судлал, угсаатны судлал, түүх, ардын билиг судлалын баримт, материалууд нь Монгол, Өрнө, Дорно дахины зарим гол орнуудын гэр бүлийн зан заншлын уламжлалыг холбон судлах үндэс болж байна.

Монгол улс болон гадаадын улс орнуудад Монголын түүх, соёлын судалгаа хийгдэж байгаа ч Монгол гэр бүлийн зан заншлыг Өрнө, Дорно дахины гэр бүлийн зан заншлын уламжлалтай зэрэгцүүлсэн судалгаа хийгдээгүй өнөөг хүрчээ.

Эдүгээ Монгол улстай азийн төдийгүй Төв, Баруун Европ, Хойт Америкийн орнуудын харилцаа өргөжин гүнзгийрч байгаа нөхцөлд Монголынхтой дээрхи орнуудын гэр бүлийн зан заншлын уламжлалын нийтлэг тал, онцлогийг судлах нь шинжлэх ухааны болон практик ач холбогдолтой асуудал болж байна.

Монгол, Өрнө дорно дахины зарим голлох орнуудын гэр бүлийн зан заншлын хүрээнд дараахи нийтлэг талууд байна.

- Гэр бүлийн зан заншлын уламжлалын хувьд Өрнө, Дорно дахины орнуудаас Монгол, Зүүн хойт Азийн орнууд хоорондоо илүү төстэй байдгийн нэг суурь дэвсгэр нь Их гэр бүл юм.

- Их (Том Т.Н.) гэр бүлд гурваас дөрвөн үеийнхэн амьдарцгааж, эцэг өвгөд нь залгамж хойч үеэ амьдрах, аж төрөх ухаанд сургаж, өөрөөр хэлбэл Их гэр бүл нь ёс, зан заншлын тогтолцооны төв болсоор ирсэн.

- Их гэрээс хүүхдүүд нь айл гэр болон тусгаарласнаар Бага гэр бүлүүд үүсч, зан заншил үр хүүхдийг хүмүүжүүлэх гол үүргийг хүлээсээр байгаа.

- Овогоо, эцэг өвгөдөө эрхэмлэсээр удам угсаагаа хадгалж, Угийн бичиг (Гэрийн түүх)-ийг хөтөлж, тэр нь өвлөгдсөөр ирсэн. Угийн зураглалын тэмдэг, тэмдэглэгээнд адил буюу төстэй талууд байгаа. Солонгосчуудын Угийн бичгийн тэмдэглэгээ эрт үеийн байдлыг илүү хадгалсан байдалтай.

- Ураг төрөл, угийн бичгээ үеэс үед сайн мэдэхийг эрмэлздэг. Хүүгээ хэний охинтой, охиноо хэнийхний хүүтэй ханилуулах вэ? гэдэгт анхаарч ирсэн түүхтэй байна.

- Гэр бүлийн зан заншлын уламжлалд аман зохиолын төрөл хэлбэрүүд нэгэн гол байрыг эзэлсээр иржээ.

Эдгээрийг онолын үүднээс авч үзвэл Төв Азиас нүүдэллэсэн хүмүүс өөр өөр замаар хөгжихдөө хувирч өөрчлөгдсөн хэдий ч урьдынхаа нийтлэг талыг ямар нэгэн хэмжээгээр хадгалан үлджээ.

Өрнөдийн ард түмэн эрт цагаас Евразийн орнуудын ард түмний оюун санааны уламжлалын нийтлэг хүрээнд хамрагдаж, харилцан нөлөөлөлтэй байжээ.

Хүн судлалын эрдэмтэд Монгол, Солонгос хүний үс, зүс, нүд нүүрний төрх тун ойр гэж үзсэн байхад, хэл судлаач эрдэмтэд Монгол, Солонгос хэлний салсан он цагийн багцааг одоогоос 4 мянгаад жилийн буюу Монголын хүрлийн үеэс гэж үзсэн байна.

Энэ мэтээр эртний болон угсаатны судлал, аман зохиол судлалын харьцуулсан судалгаа, ялангуяа Монгол, Солонгос, Японы эрдэмтдийн дунд хийгдэх боллоо.

Тэгвэл бид Монгол, Өрнө, дорнын ард түмнүүдийн оюун санааны амьдралын чухал бүрэлдэхүүн хэсэг, нийгмийн нэгдлийн үндэс, анхны нэгж болсон гэр бүлийн зан заншлын уламжлалд ямар нийтлэг, адил төстэй талууд байна вэ? гэдэгт түүхэн угсаатны зүйн үүднээс хандаж байна.

Монгол, Өрнө, Дорнын орны ард түмний оюун санааны үнэт уламжлалын бүрэлдэхүүн хэсэг - гэр бүлийн зан заншлын хөгжлийн түүхийн уламжлалын дүр төрх, түүхэн холбоо, харилцан нөлөөллийг аль болох өргөн хүрээгээр өөрөөр хэлбэл дэлхий дахины хүрээнд ойртуулан, учир зүйн холбооны үүднээс хандан Монголынхтой жишиж тайлбарлах оролдлого хийх зорилгыг тавьж байна.

Ер нь гэр бүлүүд нэгэнт бүрэлдэн хэвшсэн нийгмийн харилцааны гол шинж болж байдаг.

Өрх гэрийн бүтэц, өрхийн гишүүдийн хоорондын харилцаа, ураглах, төрөлсөх ёс зэрэг нь нэгэн бүхэл бүтэн цогцолбор асуудал юм.

Өрх гэр нь тухайн үеийн нийгмийн болон аж ахуйн нэгж болдог.

Өрх гэрийн шинж төрхийг тодорхойлоход нийгмийн харилцааны болон ардын ёс байдлын талаас авч үзэхэд тухайн орны хүмүүсийн угсаа, соёлын өвөрмөц шинж төрх харагддаг. Тиймээс өрх гэрийн хүрээнд хийх судлалыг анхаарч байгаа юм.

Эрдэмтэн Х.Пэрлээ “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь” зохиолынхоо 46 дахь талд: “Нийт эрдэмтэд, археологич, угсаатны зүйч, түүхчид Ази, Америк хоёр тивийн нутгийн хүн амын нийтлэг удам судрын тухай асуудлыг тал талаас нь унхиагаа авалцан шинжиж байгааг баримжаа болгон бодоход бид монгол овгийн ул мөрийг зөвхөн үндсэн нутаг дэвсгэртээ биш, Азийн манд холбогдох улс оронд хийж, тив алгасан дэлхийн бусад ухаантны сүрэгт нийлэлдэн Америкийн байтугай, Африкт ч хийх нь зүйтэй болсон болов уу” (/3/) хэмээн үлдээсэн нь биднийг Монгол, Өрнө, Дорнын гэр бүл судлалыг хөгжүүлэх асуудлыг дэвшүүлэн тавихад хүргэсэн юм.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Н.Ишжамц. "Монголд нэгдсэн төр улс байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь". УБ., 1974
2. Т.Намжил. "Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал, түүнийг Зүүн хойт азийн орнуудынхтай харьцуулан судалсан нь". (Докторын зэрэг горилсон диссертаци). УБ., 1997
3. Х.Пэрлээ. "Монгол түмний гарлыг тамгаар хийж судлах нь". УБ., 1976
4. Ф.Энгельс. "Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл". Түүвэр зохиол. III боть УБ., 1971.
5. А.Антонов. "Микросоциология семьи". М., 1998
6. Р.Зидер. "Социальная история семьи в Западной и Центральной Европе (конец XVIII-XX вв)". М., 1997
7. Цукишима Кэнзо. "Нихонжин о кангаэру хикаку шинри но татибадэ". Токио. 1997
8. Anderson M. Approaches to the History of the Western Family 1500-1914. London. 1980
9. Korean family and Kinship. Korean Studies Series №3. Lee Kweng-gyu. 1998

Шинэ номын танилцуулга

"Монгол, Өрнө, Дорно: Гэр бүлийн зан заншлын уламжлал, холбоо". III дэвтэр. 128 хуудастай

Эл номонд өрх гэрийн зан заншил, уламжлал, түүний үүргийг гаргахын хамтад гэр бүлийн зан заншлын уламжлалыг тодорхойлох үндсэн чиглэл болох: Их гэр бүл, Овог, Ураг - садан төрлийн холбоо, Угийн/гэрийн/бичиг, өв хөрөнгө залгамжлах ёс зэрэг чиглэлүүдээр Монгол, Өрнө, Дорнын гэр бүлийн зан заншлын холбоо, уламжлалыг гаргах оролдлогыг хийсэн байна.

Эл ном нь Монгол, Өрнө, Дорнын ард түмнүүд угсаа гарвалын түүх, соёлын холбоо, харилцан нөлөөллийг тодруулахад шууд биш ч гэсэн нэгэн хүчин зүйл болох нь дамжиггүй.

Номыг: Доктор Т.Намжил бичиж, Академич Ч.Далай редакторлажээ.

Номыг Зүүн хойт Ази судлалын төвөөс /хуучин нэрээр/ эрхэлж гаргасан байна.